

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин. ....	4
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	7
3. Менежментийн захидал .....	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББТ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШУА	Шинжлэх ухааны академи
ТШЗ	Төсвийн шууд захирагч



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ГЕОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
ЗАХИРАЛ Д.ОДГЭРЭЛ ТАНАА

2020.02.27 № 06/622  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтад заасны дагуу Геологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Геологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Геологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Геологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг хүрээлэнгийн захирал Д.Одгэрэлд танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Геологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Геологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 12-аас 2020 оны 2 дугаар сарын 23-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, "Ол дөш хайрхан аудит" ХХК-ийн аудитор Г.Рэнцэнханд аудиторын туслах Б.Удвал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Геологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг "Ол дөш хайрхан аудит" ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.

Геологийн хүрээлэнгийн эрхэм зорилго "Монголын геологи судлалыг олон улсын хэмжээнд хөгжүүлэн шинэ мэдлэг хуримтлуулах, ололтыг түгээх бөгөөд геологи судлалын

*чиглэлээр онолын суурь судалгаа, судалгаа боловсруулалтын ажлыг орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн түвшинд гүйцэтгэх, судалгааны ажлын үр дүнг үйлдвэрлэл практикт нэвтрүүлэн эх орныхоо нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад оршино.”*

Геологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын шинжлэх ухааныг хөгжүүлэх;
- Судалгаа боловсруулалтын ажил эрхлэх;
- Мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх;
- Төсөл хэрэгжүүлэх;
- Инновацыг бий болгож үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах, патентлах, олон улсын байгууллага болон гадаад орнуудаас эрдэмтэн мэргэжилтэн урьж хамтарч ажиллах, өөрийн эрдэмтэн мэргэжилтнийг гадаад орнуудад явуулах асуудлыг шийдвэрлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дугаар тушаалаар баталсан.

Геологийн хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашиглаж байна.

Геологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Геологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 160,890.7 мянган төгрөгөөс тооцон 1,608.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг төлөвлөлтийн үеийнхээр тооцсон болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 328 дугаар тогтоолоор Палеонтологи, Геологийн хүрээлэнг 2 хүрээлэн болгож зохион байгуулсан бөгөөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 430 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг хэрэгжүүлсэн байна.

Шинээр зохион байгуулагдсан Геологийн хүрээлэн нь оны эцэст авлага 304.4 мянга, бараа материал 27,536.9 мянга, үндсэн хөрөнгө 77,355.7 мянга, нийт 105,197.0 мянган төгрөгийн хөрөнгөтэй байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд зааснаар Геологийн хүрээлэн тайлант онд 1,036.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөө бүтэжигдсэнээр төлөвлөгөөг 100 биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Өөрийн орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,036.0	1,036.0	00.00	100.0
Нийт дүн	1,036.0	1,036.0	00.00	100.0

Тус хүрээлэнгийн төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан улсын төсвөөс 136,893.2 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авахаар төсөв батлагдсаныг бүрэн авч, үйл ажиллагааны урсгал зардалд 136,875.3 мянган төгрөг зарцуулж 17.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 136,875.3 мянган төгрөг буюу 99.9 хувийг зарцуулсан байна.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсвийн захирагчаас 24,338.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 24,015.4 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 304.4 мянган төгрөгийн улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл: бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр 19,980.3, хичээл үйлдвэрлэлийн дадлага 3,000.0, урамшуулал 413.4 нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 621.6, нийт 24,015.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 2 эрсдэл тогтоож, гүйцэтгэх үе шатанд 5 эрсдэл тодорхойлж, нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 644.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

1. Стаус программаар Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үзүүлэлтийн уялдааг тулган шалгахад: Улс төсөвт төвлөрүүлсэн мөнгийг зардалд, хуримтлагдсан үр дүн дансанд тайлагнасан. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан заавартай нийцэхгүй, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ тухай хуулийн 15 дугаар зүйл, НББ-ийн алдааг залруулах, 15.1" ААН, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн

*залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." 15.2" НББ-ийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу залруулга хийлгэсэн.*

2. Санхүүгийн байдлын тайлангийн нийт Нийт хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүнг зөрүүтэй илэрхийлсэн. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан заавартай нийцэхгүй, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББ тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасныг үндэслэн санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Геологийн хүрээлэнгийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 24 мэдээллийг байршуулсан байна.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Геологийн хүрээлэн нь 2019 оны 8 дугаар сард байгуулагдсан.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Геологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт

Геологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



### 3. Менежментийн захидал

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил нь НББ тухай хуулийн 15 дугаар зүйлийн НББ-ийн алдааг залруулах, 15.1-т " ААН, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т " НББ-ийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу аудитын явцад залруулагдсан учир Менежментийн захидалд бичигдэх алдаа зөрчил байхгүй болно.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	27,841,264.00
33	АВЛАГА	00.00	304,400.00
30	Татаас санхүүжилтийн авлага	00.00	304,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	00.00	27,536,864.00
351	Түүхий эд материал	00.00	1,899,696.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	1,899,696.00
354	Хангамжийн материал	00.00	25,637,168.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	64,000.00
35420	Аж ахуйн материал	00.00	368,512.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	25,204,656.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	77,355,685.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	00.00	77,355,685.93
392	Биет хөрөнгө	00.00	76,489,435.93
39205	Машин, тоног төхөөрөмж	00.00	36,400,307.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	00.00	(1,166,960.75)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	00.00	3,014,704.92
39208	Хуримтлагдсан элэгдэл	00.00	(244,448.68)
39213	Түүх соёлын дурсгалт зүйлс	00.00	35,706,905.00
39217	Номын фонд	00.00	2,778,928.00
393	Биет бус хөрөнгө	00.00	866,250.00
39301	Программ хангамж	00.00	1,155,000.00
39302	Хасагдуулаг	00.00	(288,750.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	00.00	105,196,949.93
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	00.00	105,196,949.93
51	Засгийн газрын хувь оролцоо	00.00	105,196,949.93
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	00.00	72,452,332.36
51101	Өмч: -Төрийн өмч	00.00	00.00
512	Хуримтлагдсан үр дүн	00.00	32,744,617.57
51210	Өмнөх үеийн үр дүн	00.00	(72,452,332.36)
51220	Тайлант үеийн үр дүн	00.0	105,196,949.93
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	00.00	105,196,949.93

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	262,137,381.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	100,905,981.36
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	100,905,981.36
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	0.00	100,905,981.36
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	100,905,981.36
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	161,231,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	136,893,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	136,893,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	24,338,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	0.00	23,302,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	1,036,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	0.00	156,940,431.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	156,940,431.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	155,582,505.09
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	111,014,781.99
210101	Цалин	0.00	79,338,116.71
210102	Нэмэгдэл цалин	0.00	31,263,227.28
210104	Урамшуулал	0.00	413,438.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	14,057,951.11
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	0.00	9,815,514.48
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	0.00	1,157,213.44
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	0.00	892,490.75
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	0.00	218,248.49
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	0.00	1,974,483.95
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	3,153,691.56
210401	Бичиг хэргийн материал	0.00	1,020,500.00
210403	Шуудан холбоо интернэтийн төлбөр	0.00	320,102.56
210404	Ном, хэвлэлийн зардал	0.00	52,692.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	0.00	1,760,397.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	4,745,000.00
210604	Урсгал засвар	0.00	4,745,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	0.00	17,910,921.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	17,910,921.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	4,700,159.43
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	0.00	3,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	1,700,159.43
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,357,926.34

2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,321,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	0.00	621,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	36,326.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	17,905.34
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		18,421.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	0.00	105,196,949.93
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	0.00	105,196,949.93

#### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	161,231,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	161,231,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	136,893,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	136,893,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	24,338,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	23,302,200.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	1,036,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	0.00	156,199,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	156,199,500.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	154,537,173.66
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	0.00	111,014,781.99
210101	Үндсэн цалин	0.00	79,338,116.71
210102	Нэмэгдэл	0.00	31,263,227.28
210104	Үр дүнгийн урамшуулал	0.00	413,438.00
2102	Ажил ологчоос нийтийн даатгалд төлөх шимтгэл	0.00	14,057,951.11
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	0.00	9,815,514.48
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	0.00	1,157,213.44
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	0.00	892,490.75
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	0.00	218,248.49
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	0.00	1,974,483.95
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	2,399,999.56
210401	Бичиг хэрэг	0.00	1,084,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	320,102.56
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	995,397.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	4,845,100.00
210601	Багаж техник хэрэгсэл	0.00	100,100.00
210604	Урсгал засвар	0.00	4,745,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	19,219,341.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	0.00	19,219,341.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,000,000.00
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,662,326.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,321,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	700,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	0.00	621,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	340,726.34
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	17,905.34
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	322,821.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	5,031,900.00

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	5,031,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	5,031,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	5,031,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	(5,031,900.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	00.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-72,452,332.36	-72,452,332.36
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>		<b>-72,452,332.36</b>	<b>-72,452,332.36</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	72,452,332.36	00.00	72,452,332.36
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	105,196,949.93	105,196,949.93
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>72,452,332.36</b>	<b>32,744,617.57</b>	<b>105,196,949.93</b>

#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	136,893,200.00	136,875,294.66	-17,905.34	99.99
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	136,893,200.00	136,875,294.66	-17,905.34	99.99
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	136,193,200.00	136,175,294.66	-17,905.34	99.99
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	110,610,200.00	110,601,343.99	-8,856.01	99.99
210101	Үндсэн цалин	79,384,500.00	79,338,116.71	-46,383.29	99.94
210102	Нэмэгдэл	31,225,700.00	31,263,227.28	37,527.28	100.12
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,058,000.00	14,057,951.11	-48.89	100.00
210201	Тэтгэврийн даатгал	11,560,000.00	9,815,514.48	-1,744,485.52	84.91
210202	Тэтгэмжийн даатгал	624,500.00	1,157,213.44	532,713.44	185.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	499,600.00	892,490.75	392,890.75	178.64
210204	Ажилгүйдлийн даатгал	124,900.00	218,248.49	93,348.49	174.74
210205	Эрүүл мэндийн даатгал	1,249,000.00	1,974,483.95	725,483.95	158.09
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,400,000.00	2,399,999.56	-0.44	100.00
210401	Бичиг хэрэг	400,000.00	1,084,500.00	684,500.00	271.13
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00	320,102.56	-179,897.44	64.02
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	995,397.00	-504,603.00	66.36
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,745,000.00	6,745,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210602	Тавилга	4,745,000.00	4,745,000.00	0.00	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,380,000.00	2,371,000.00	-9,000.00	99.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,380,000.00	2,371,000.00	-9,000.00	99.62
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	700,000.00	700,000.00	0.00	100.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	700,000.00	700,000.00	0.00	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	700,000.00	700,000.00	0.00	100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	136,893,200.00	136,875,294.66	-17,905.34	99.99
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	136,893,200.00	136,875,294.66	-17,905.34	99.99
131001	Улсын төсвөөс санхүүжих	136,893,200.00	136,875,294.66	-17,905.34	99.99
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1		
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	35	35		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	28	28		
620003	Үйлчлэх ажилтан	6	6		



#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>24,015,379.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	00.00	24,015,379.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	00.00	23,393,779.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	00.00	413,438.00
210104	Урамшуулал	00.00	413,438.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	19,980,341.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	19,980,341.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	3,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	3,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	621600
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	621,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	621,600.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>00.00</b>	<b>24,015,379.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	24,015,379.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	22,979,379.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	1,036,000.00

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.17	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	Геологийн хүрээлэн			САГ-2020/355/13СТА-ТШЗ
				Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Стаус программаар Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үзүүлэлтийн уялдааг тулган шалгахад Улс төсөвт төвлөрүүлсэн мөнгийг зардал, хуримтлагдсан үр дүн дансанд бичсэнийг засуулж залруулга хийлгэх.	0.3	Санхүүгийн тайланд залруулга хийлгэх	Захирал Нягтлан бодогч	Д.Одгэрэл Б.Соёлмаа
2	Санхүүгийн байдлын тайлангийн Нийт хөрөнгө, өр төлбөр цэвэр хөрөнгө өмчийн дүнг зөрүүтэй илэрхийлснийг илрүүлж залруулга хийлгэх.	0.3	Санхүүгийн тайланд залруулга хийлгэх	Захирал Нягтлан бодогч	Д.Одгэрэл Б.Соёлмаа
3	Нягтлан бодох бүртгэлийн дансны үлдэгдэл, гүйлгээг санхүүгийн тайлан, тодруулгад зөрүүтэй тусгагдсан байх		Санхүүгийн тайланд залруулга хийлгэх	Захирал Нягтлан бодогч	Д.Одгэрэл Б.Соёлмаа
	<b>Дүн</b>	<b>0.6</b>			



